



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№68 /512/

2023.04.26

Цаг үе, үйл явдал

СЭТГҮҮЛЧИД ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах уламжлалт арга хэмжээгээ энэ жил "Иргэн-цэргийн харилцаа" сэдвээр 4 дүгээр сарын 26-ны энэ өдөр зохион байгуулж байна. Нөхөрсөг уулзалт, ярилцлагын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд орон нутагт шилжин байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал болон эгнээнээсээ 10 баатар төрүүлсэн, 2023 онд түүхт 100 жилийнхээ түүхийг бичиж байгаа Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд зочилж, хугацаат цэргийн алба хаагчдын орчин нөхцөл, хангалт үйлчилгээ, сургалт бэлтгэлтэй танилцаж, тэдний санал сэтгэгдлээс хуваалцаж байна.

Сэтгүүлчид эхлээд командлалын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Д.Өлзийбаяр Хуурай замын цэргийнхний сүүлийн үеийн ололт амжилт, тэр дундаа хугацаат цэргийн алба хаагчидтай явуулж байгаа сургалт бэлтгэл, соёл хүмүүжил, сэтгэл зүйн дэмжлэг, сурталчилгаа, мэдээллийн тухай голчлон ярилаа. Үүний дараа Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт нар сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулав.

Сэтгүүлчдийн зүгээс "ОХУ, Украины сөргөлдөөнтэй дайны байдалд Монгол Улсын Зэвсэгт ямар үнэлэлт өгч, хэрхэн аюул ослоос сэргийлж байна", "Хугацаат цэргийн алба хаагчдын эрүүл мэндэд ямар дэмжлэг үзүүлж байна. Сүүлийн үеийн залуус буруу дадал хэвшлээс болж өвчлөмтгий болсон", "Зэвсэгт хүчин олон нийтэд илүү ил тод байх ёстой. Хугацаат цэргийн алба хаагчдыг өдөр тутмын үйл ажиллагаа эцэг, эхэд нь нээлттэй байх ёстой. Тэгж байж бид хүүхдээ явуулна", "Хугацаат цэргийн алба хаагчдын алба хаах хугацааны хувьд өөрчлөлт орох уу. Гурван жилийн цэрэг хамгийн сайн бэлтгэгддэг гэж ахмадууд ярьдаг" зэрэг асуулыг тавив.

Бригадын генерал Ч.Цогтжаргал "Монгол Улсын аюулгүй байдалд бүх нийтийн оролцоо хамгийн чухал. Тэр дундаа ард түмнээ соён гэгээрүүлэх, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын үнэ цэнийг олон нийтэд ойлгуулах, цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг түгээн сурталчлахад сэтгүүлчид та бүхний үүрэг асар их. Энэ бол та бүхний эх орныхоо өмнө байгуулж байгаа гавьяа гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, цэргийн алба өөрөө иргэний нийгмээс өөр. Өдөр тутмын үйл ажиллагаа нь хүртэл тогтсон дүрэм журмын хүрээнд явагдаж, алба хаагчдаа болоод хугацаат албаны дайчдаа сургаж бэлтгэдэг. Тэгэхээр хугацаат цэргийн албанд анх татагдсан залууст албандаа дасах хүртлээ хэцүү санагддаг байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ халагдахдаа баярласнаа илэрхийлж, уйлаад л буцдаг. Энэ нь цэргийн нөхөрлөл, албаны үнэ цэн оршиж байна гэсэн үг.

Гуравдугаарт, Зэвсэгт хүчин гэдэг зарим талаараа нууц байх ёстой. Дэлхийн орнуудын Зэвсэгт хүчин тийм. Бүх мэдээллээ дэлгээд байвал аюулгүй байдалд асар хор нөлөөтэй байдгийг сэтгүүлчид та бүхэн ойлгох ёстой. Гэхдээ бид нийгмийн хандлага, хөгжлөөс шалтгаалан зарим асуудалд аль болох нээлттэй байхыг зорьж байна. Ялангуяа хугацаат цэргийн алба хаах орчин нөхцөлтэй танилцахад ар гэр, харьяа дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, орон нутгийн удирдлага, сэтгүүлчдэд үргэлж нээлттэй байдаг. Өнөөдөр Зэвсэгт хүчин хугацаат цэргийн алба хаагчдаа олон боломж нэмэгдүүлж, хөгжиж дэвших, суралцахад нь дэмжлэг үзүүлж, ар гэрийнхэнтэй нь ч 14 хоног тутамд нь цахимаар "уулзуулж" байна". Харин хугацааны хувьд богино хугацаанд олныг бэлтгэх үү, урт хугацаанд цөөн хэсгийг бэлтгэх үү гээд янз бүрийн санал байдаг. Судалгааны шатанд явагдаж байгаа" гэсэн мэдээллийг өгсөн юм.

Энэ үеэр "Иргэн-цэргийн харилцаа" уулзалт, ярилцлагыг зохион байгуулагч болон оролцогчдын сэтгэгдлийг нь хуваалцлаа.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт:

"Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад сурталчлах хүрээнд өнөөдрийн



"Иргэн-цэргийн харилцаа" сэдэвт уулзалт, ярилцлагыг зохион байгуулж байна. Энэ бол Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын уламжлалт арга хэмжээ. Хоёр жил тутамд зохион байгуулж, цэргийн албаны орчин, хугацаат цэргийн алба хаагчдаа сурталчилдаг. Энэ удаа телевиз, сонин, веб сайтын 20 гаруй хэвлэл мэдээллийн ажилтныг сурвалжлах үүргээс нь илүүтэй зочин байдлаар урьж, цэргийн албаны онцлог, түүнд гарч байгаа өөрчлөлт шинэчлэлтийн талаар ойлголт өгч байна. **Asu.mn веб сайтын тоймч О.Сайханцэцэг:**

"Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн гэдэг эх орон, тусгаар тогтнолынхоо төлөө тангараг өргөөд, түүндээ чин үнэнчээр зүтгэдгээр нь бид бахархдаг. Энэ ажил албыг Монголын аавын хүү, ээжийн охин заавал гүйцэтгэх ёстой. Тэгж байж эх орон элэг бүтэн оршино. Надад хугацаат цэргийн алба хаагчидтай холбоотой асуух зүйл их байсан ч тэднийг сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд нь бодитой ажлууд хэрэгжүүлж байгааг нь сонсоод талархаж суулаа. Одоо Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд үргэлжлүүлэн ажиллахдаа алба хаах орчин нөхцөлтэй илүү дэлгэрэнгүй танилцана. Ирээдүйд эр цэргийн алба хаах хүүтэй эх хүний хувьд цэргийн алба хаах орчин нөхцөл тогтоосон дүрмийн хүрээнд явагддаг байгаасай л гэж хүснэ. Дүрмийн бус харилцаа ерөөс байж болохгүй.

Унуудур.mn веб сайтын сэтгүүлч Б.Мөнхсайхан:

"Бид Зэвсэгт хүчин гэхээр нэг л том байгууллага гэж ойлгодог. Гэтэл гүйцэтгэх үүргээсээ хамааран төрлийн цэргийн командлал болон биеэ дааж, үйл ажиллагаа явуулдаг юм байна. Төрлийн цэргийн командлалуудынхаа бие даасан байдалд ч БХЯ, ЗХЖШ-аас онцгой анхаардаг юм байна. Өнөөдөр бидний зочилсон Хуурай замын цэргийн командлал гэхэд төрийн бүх байгууллага дотроо жишиг нь болохуйц байна гэж харлаа. Сургалт бэлтгэлийн танхимууд, бялдаржуулах төв, эмнэлэг, номын сан, музей, бүр кофе шоп ч байна. Бидэнд зориулаад "Хуурай замын цэрэг" гээд сонинг хүртэл бэлтгэсэн байхыг хараад зохион байгуулалт, эмх цэгц, дэг журам гэдэг ийм л юм байна гэдгийг ойлгож суулаа" гэсэн юм.

Ахмад Д.БОЛОР



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 9	☁ -7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 37	☁ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,476	3,485
EUR	3,835	3,860
CNY	502	505
RUB	42	42.50
JPY	26	26.20
KRW	2.62	2.65

ЗУРХАЙ

2023.04.26 /ЛХАГВАГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 6

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ
САР
НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ
ХӨХ БАР ӨДӨР**

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.43-19.57

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

АВАХУЙ

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. / муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 686,647,374

Эдгэрсэн

Нийт: 659,229,694

Нас барсан

Нийт: 6,860,779

Цахим шууданд

ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЁНДОНГИЙН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



байсан юм. Тэрээр 17 насандаа өөрийн саналаар цэргийн албанд мордож, 1940-1942 онд Тамсагбулгийн домогт 6 дугаар морьт дивизийн 15 дугаар морьт хороонд цэрэг, бага даргаас армийн амьдралаа эхлүүлсэн бөгөөд ухамсарт амьдралынхаа 50 гаруй жилийг төр, цэргийн их үйл хэрэгт зориулжээ. Ингэхдээ эрхэлсэн ажил, албандаа ямагт манлайлагч байсан нь өнөөдөр ч бахархалтайгаар дуурсагдаж байна. Тус эрдэм шинжилгээний хурал нь хурандаа генерал Ж.Ёндонгийн төр, цэргийн зүтгэлтэн болж төлөвших их үйлийнх нь түүхэн замналыг эргэн судалж, алдар гавьяаг нь мөнхжүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан юм. Эрдэм шинжилгээний хурлаар "Монгол төрийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Жамсрангийн Ёндон", "Хурандаа генерал Ж.Ёндонгийн цэргийн хэрэгт оруулсан хувь нэмэр", "Нэрт сурган хүмүүжүүлэгч, соён гэгээрүүлэгч, хурандаа генерал Ж.Ёндон", "Монгол цэргийн музейд хадгалагдаж байгаа хурандаа генерал Ж.Ёндонгийн гэрэл зургийн судалгаа" зэрэг сэдэвт үндсэн болон хавсралт илтгэлүүдийг хэлэлцүүлсэн юм.

Ахлах дэслэгч Ц.НАМЖИЛМАА

Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэн үүсэн байгуулагдсаны 45 жилийн ойн хүрээнд тус хүрээлэн "Ерөнхий цэрэг ассоциаци" төрийн бус байгууллагатай хамтран ХХ зууны Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Ж.Ёндонгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан "Цэргийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал

Ж.Ёндон-100 жил" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Хурандаа генерал Ж.Ёндон нь өсөх залуу наснаасаа эхлэн Монголын Зэвсэгт хүчинд зүтгэж байдагчаас генерал, ЗХЖШ-ын дарга, Батланхамгаалахын сайдаас төрийн түшээ, ардын их хурлын депутат хүртэл дэвшин ажилласан төр, цэргийн нэрт зүтгэлтэн



АНГЛИ ХЭЛНИЙ ОЛИМПИАДАД 24 ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ОРОЛЦОНО



өдөр зохион байгуулна.

Олимпиадад оролцохоор нэгтгэл, ангиасаа шалгарсан 24 офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдад командлалын Сургалт бэлтгэлийн хэлтсийн Гадаад хэлний сургалтын төвийн дарга ахлах дэслэгч Э.Ариунзаяа тэмцээний журам, явагдах дараалал, үнэлгээ дүгнэлтийн талаарх мэдээллийг 4 дүгээр сарын 25-ны энэ өдөр өглөө.

Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын алба хаагчдын дунд анхлан явагдаж байгаа энэхүү олимпиадад оролцогчид унших, бичих, сонсох, орчуулах чадвараараа өрсөлдөх бөгөөд англи хэлний мэргэжлийн сургалтын байгууллага дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаадын сургууль, дамжаа, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх,

гадаад хэл сурах хүсэл эрмэлзлийг идэвхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас харьяа нэгтгэл, ангийн бүрэлдэхүүний дунд "Англи хэлний олимпиад-2023" тэмцээнийг 4 дүгээр сарын 26-ны



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭМЧ НАР УВС АЙМАГТ АЖИЛЛАЛААХ



Цэргийн төв эмнэлгийн комисс Увс аймагт ажиллаж хугацаат цэргийн алба хаах насны иргэдийн эрүүл мэндийн асуудлаар нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын удирдлага, цэрэг татлагын товчооны эмч нартай сургалт явууллаа.

Сургалтад нэгдсэн эмнэлгийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сумдын ЗДТГ-ын дарга нар хамрагдсан юм.

Мөн уг ажлын хүрээнд цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй иргэдэд эрүүл мэндийн үзлэг явуулж хугацаат цэргийн албанаас чөлөөлөх ажлыг зохион байгууллаа.

УВС АЙМГИЙН ЗДТГ ЦЭРГИЙН ШТАБ

СЭТГЭЛ ЗҮЙН БҮЛЭГ ТУСГАЙ БАТАЛОНД АЖИЛЛАА



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон "Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг" Зэвсэгт хүчний 330 дугаар ангид ажиллалаа.

ЗХЖШ-ын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга хурандаа Ү.Хүрлээ "Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг"-ийн зорилго чиглэл, гарах үр дүнгийн тухай танилцуулсан бол үргэлжлүүлэн сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлийнхэн сургалт, оношилгоо, зөвлөгөөнийг зохион байгуулж, бүрэлдэхүүний сэтгэл зүйн онцлогуудыг илрүүлэн, хувь хүн, алба, тасаг, салбар, ангийн хэмжээнд үр дүнг нь боловсруулан танилцуулав.

Бүлгийн багш нар хувь хүний

чадваруудыг илрүүлэх "Хамт олны сэтгэл зүй", "Харилцааны сэтгэл зүй", "EQ", "Зөрчил маргааны сэтгэл зүй", "Цаг ашиглах чадварын сэтгэл зүй" зэрэг 5 төрлийн оношилгоо сургалтыг сонирхолтой байдлаар зохион байгуулж хүн бүрт тохирсон зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан нь нийт бие бүрэлдэхүүний талархлыг хүлээсэн явдал боллоо.

Уг сургалт ажилтан, цэргийн алба хаагчдын албандаа хандах хандлага, сэтгэл зүйн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол үзүүлсэн тул ангийн зүгээс ахин энэ төрлийн сургалтыг авах хүсэлтэй байгаагаар уламжиллаа.

Хошууч Э.ГАНЦООЖ



"МОНГОЛ ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР"-ЫГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ МОНГОЛ БИЧГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт "Монгол үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна", Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн 3.3.5-т "Төрийн байгууллагууд байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын сургалтын хөтөлбөрт ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг жил бүр төлөвлөх, тусгайлан хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнах", мөн хөтөлбөрийн 3.3.7-д "Төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх" гэж тус тус зааж энэхүү хуулийг 2025 оноос эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Монгол үндэстний утга соёлын нандин өв болсон Монгол бичгийг хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших сонирхлыг дэмжих, Монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх, Уйгаржин бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулахад уралдааны зорилго оршино.

Оролцогчдын ангилал, чиглэл:

Монгол бичгийн уралдаанд Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын генерал, офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, ажилтан албан хаагчид оролцоно. (Монгол бичгийн мэргэжлийн багш оролцохгүй)

Оролцогчид 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газарт бүртгүүлнэ.

Уралдааныг дараах 4 төрлөөр явуулна. Үүнд:

- Алдаагүй зөв бичих
- Таталган бичгийг алдаагүй зөв унших
- Цэвэр сайхан бичих
- Уран бичлэг

Оролцогч баг, хувь хүн аль төрөлд орохоо өөрөө сонгоно.

Дүн гаргах

Нэгдсэн дүнг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр гаргана. Жич: Хөдөө орон нутгийн нэгтгэл, анги, байгууллагаас оролцож байгаа албан хаагчдын тээврийн зардлыг тухайн анги, байгууллага харуцна.

Төрөл тус бүрийн шилдэг 3 оролцогчийг тэргүүн байр, дэд байр, гутгаар байр эзлүүлэн өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төв хэвлэл "Соёмбо" сониноор сурталчилна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Д/д	Уралдааны төрөл	Хугацаа	Байршил	Тайлбар
1	Алдаагүй зөв бичих	2023.05.03 09.00 цагт		
2	Таталган бичгийг алдаагүй зөв унших	2023.05.03 12.00 цагт	БХЯ, ЗХЖШ-ын 320 дугаар танхимд	
3	Цэвэр сайхан бичих	2023.05.03 15.00 цагт		
4	Уран бичлэг	2023.05.04 09.00 цагт		